



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар А/97

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211, 2020 оны "Зөвлөмж батлах тухай" 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Есөнбулаг сумын Харзат багийн нутаг дэвсгэрт "Шинэ-Алтай" ХХК-ийн хувийн хөрөнгө оруулалтаар баригдсан худалдаа үйлчилгээний барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Д.Гаадамба	-(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд:	М.Мандахүү	-(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Ц.Амарсанаа	-(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
	Д.Отгонжаргал	-(Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)

2.

Б.Батбилэг -(Мэргэжлийн хяналтын газрын
Барилгын техникийн хяналтын улсын
байцаагч)

Б.Баасанцэрэн -(“Уран-Охид” ХХК-ийн инженер)
(гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга: Ч.Батдэлгэр -(“Шинэ-Алтай” ХХК-ийн захирал)

2.Барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2022 оны 02 дугаар сарын 04-ний дотор танилцуулахыг комисс (Д.Гаадамба)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР